



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2019 оны 07 сарын 22-өдөр

Дугаар 293

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар  
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 3, 4.2, 4.3 дахь заалт, 2019 оны 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 56,784,300.00 (тавин зургаан сая долоон зуун наян дөрвөн мянга гурван зуун) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Л.Энхбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1 Үндсэн хөрөнгийг дуудлагаар худалдах ажлын хэсэг томилж, холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2 Дуудлага худалдааны зарыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын цахим хуудсанд байршуулах;

2.3. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.4 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.5. Арга хэмжээний биелэлтийг батлагдсан маягтын дагуу гарган 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
TYP ORLOON ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ  
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



0000547

Төрийн өмчийн бодлого, зохицуулалт

2019 оны 07 дугаар сарын

293 дугаар тогтоол

"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн  
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашини жагсаалт

Одомашины марк, дугаар, зориулалт, түүр, арлын дугаар	Ашиглал тад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Сэргээн босголтын зардал (төгрөг)	Х
2054" автобус, 02- суудлын, 39	2005	376000	24,288,500.00	24,288,500.00	0	0	
0", 22-26 OPA, 2380831	1988	387000	8,202,300.00	8,202,300.00	0	0	
054" автобус, 02- суудлын, 5, 50001905	2005	366500	24,293,500.00	24,293,500.00	0	0	
Нийт дүн			56,784,300.00 (тавин зургаан сая долоон зуун наян дөрвөн мянга гурван зуун)	56,784,300.00 (тавин зургаан сая долоон зуун наян дөрвөн мянга гурван зуун)	-	-	9